

Дижитал шилжилтийн эрин үед нягтлан бодогчдод шаардагдах ур чадвар, ажлын чиг үүрэг (Голомт банкны жишээн дээр)

Required Skills and Job Functions of Accountants' in the Age of Digital Transformation (in case of Golomt Bank)

Д. Авирмэд¹, М. Анужин²

Хураангуй

Дижитал эрин зууны дэвшилтэт технологиуд бүхий л салбарт хурдацтай нэвтэрч байна. Голомт банкны нягтлан бодогчдод ажлын байран дээрх чиг үүрэг болон шаардагдаж буй ур чадварыг илрүүлэх зорилгоор асуулга болон ярилцлагын үр дүнг хослуулан боловсруулсан. Судалгааны үр дүнд нягтлан бодох бүртгэлийн үндсэн чиг үүрэгт өөрчлөлт орж, мэдээлэл боловсруулах, систем удирдах, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зэрэг шинэ чиглэлүүд нэмэгдэж, дижитал буюу техникийн ур чадвар болон зөөлөн ур чадваруудын шаардлага эрс нэмэгдэж байгааг тогтоов. Үүнтэй холбоотойгоор ажиллагсад болон байгууллагад зөвлөмжийг гаргасан болно.

Түлхүүр үгс: дижитал шилжилт, нягтлан бодогч, нягтлан бодох бүртгэл, ур чадвар, ажлын чиг үүрэг, өөрчлөлт

Abstract

Advanced technologies of the digital age are rapidly penetrating all sectors, including the banking industry. This study combines survey and interview data to identify the evolving job functions and required skills of accountants at Golomt Bank. The findings reveal significant changes in core accounting functions, with new responsibilities emerging such as data processing, system management, and decision-support tasks. The study also confirms a substantial increase in the demand for both technical (digital) and soft skills. Based on these insights, the research recommends that employees and organizations revise training programs and continuously develop professional competencies to adapt to the changing work environment.

Keywords: digital transformation, accountant, accounting, skills, job functions, change

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим

E-mail: avirmedd@num.edu.mn

² БНСУ-ын Cheongju их сургуулийн магистрант

E-mail: anujinmunkhh@gmail.com

Удиртгал

Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал болох дижитал шилжилтийн үед хиймэл оюун ухаан, блокчейн, их өгөгдөл, үүлэн тооцоолол зэрэг дэвшилтэт технологиуд эрчимтэй хөгжиж, хүн төрөлхтний амьдралд ихээхэн нөлөө үзүүлэх болсон. Тэрдундаа хөдөлмөрийн зах зээлд ээргарч буй өөрчлөлтүүд олон нийтийн анхаарлын төвд байна. “Хиймэл оюун ухаан хүн төрөлхтний ажлын байрыг булаах уу?”, “Ажлын байр устах уу, өөрчлөгдөх үү?”, “Бид үүнтэй дасан зохицох шаардлагатай юу?” гэх мэт асуултууд тулгарч байгаа ч хариулт нь тодорхойгүй хэвээр байна. Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан "Ирээдүйн ажлын байр" тайланд дурдсанаар, санхүүгийн салбарт дижиталчлалын нөлөөгөөр олон ажлын байр устах ч шинэ төрлийн ажлын байр бий болох, ажил үүргийн өөрчлөлт үүсэх талаар дурдсан (Fogum, 2020). Үүнтэй холбоотойгоор нягтлан бодогчийн ажил үүргүүд нь автоматжуулалт, хиймэл оюун ухаан (ХОУ)-аар орлуулагдах магадлалтай байгаа билээ. Иймд дижитал шилжилтийн хурдацтай холбогдуулан нягтлан бодогчийн ажлын байрны өөрчлөлтийн талаар судалж, мэргэжлийн хэрэгцээ шаардлагыг илрүүлэн, уг салбарын цаашдын чиг хандлага, мэргэжилтний дасан зохицох асуудлыг тодорхойлох шаардлага үүсч байгаа юм.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь дижитал шилжилт хийгдсэний үр дүнд нягтлан бодогчдын ажлын байрны чиг үүрэг болон шаардагдах ур чадвар хэрхэн өөрчлөгдсөнийг Голомт банкны жишээн дээр судалж, үр дүнд тулгуурласан санал зөвлөмж боловсруулахад оршино.

Судлагдсан байдлын тойм

2015 оноос эхлэн дижитал шилжилтийн улмаас бий болж буй мэргэжлийн шаардлага болон нягтлан бодогч мэргэжилтний чиг үүргийн өөрчлөлтүүдийн талаарх эрчимтэй судалгаа, шинжилгээний ажлууд хийгдэж эхэлсэн байна. Эдгээр судалгааны ажлуудаас дурдвал, Tiziana Guzzo нар (2020) Португалийн 3 жижиг болон дунд хэмжээний нягтлан бодох бүртгэлийн фирмүүдэд ярилцлага хийж, баримт бичгийн боловсруулалттай танилцаж, тематик анализ ашиглан нийтлэг хандлага болон ялгааг судалсан. Байгууллагууд дижитал шилжилтэд өөр өөр түвшинд оролцож байгаа боловч бүгд зайлшгүй дижитал технологийн хэрэгслийг эзэмшихийн сацуу аналитик болон шийдвэр гаргах ур чадвар улам чухал болсон гэж үздэг хэмээн дүгнэсэн байна.

Yunsen Chen нар (2024) Хятадын нээлттэй компаниудын өгөгдлийг ашиглан дижитал шилжилтийн нөлөөг тоон анализын аргаар шинжилсэн. Судалгааны үр дүнгээр дижитал шилжилт нь эхлэлийн түвшний нягтлан бодогчдын эрэлтийг бууруулж, тэдний эзлэх хувь багассан ба дижитал технологиуд орлох хандлагатай байгаа бол техникийн болон өндөр боловсролтой ажилтнуудын эрэлтийг нэмэгдүүлдэг болох нь тодорхойлогджээ.

Arkadiusz Januszewski нар (2024) нягтлан бодогчийн мэргэжилд дижитал шилжилтийн үзүүлэх нөлөөллийн талаарх оюутнуудын төлөвийг тодорхойлох зорилгоор Польшийн хоёр их сургуулийн бакалавр, магистр, докторын түвшний 602 оюутнаас асуулгын аргаар судалгааг хийж гүйцэтгэсэн. Оюутнуудын 79% нь нягтлан бодогчид дижитал ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх шаардлагатай гэж

үзсэн. Харин бүтээлч сэтгэлгээ, харилцаа, багаар ажиллах чадвар зэрэг зөөлөн ур чадваруудыг бага ач холбогдолтой гэж үнэлсэн байна. Оюутнуудын бараг тал хувь нь хиймэл оюун ухааны хөгжил нь нягтлан бодогчийн мэргэжилд заналхийлж байна гэж үзсэн. Докторын түвшний оюутнуудын 66% нь ажлын байр алдах эсвэл ажил олоход хүндрэлтэй болох талаар санаа зовниж байгаагаа илэрхийлсэн байна.


Авирмэд & Хүрэлбаатар нар (2021) Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн салбарт ХОУ-ын нэвтрүүлэлтийн өнөөгийн байдлыг үнэлэх зорилгоор хувийн болон улсын сектор, НББ болон бусад холбоотой ажил эрхлэгчдээс асуулгын аргаар судалгааг гүйцэтгэсэн байна. Судалгаанд оролцогчдын 73.3% нь нийлүүлэгч компанийн санал болгосон программыг, 10.4% нь ердийн оффис программыг ашигладаг ба тусгайлсан программ, ХОУ-ы ашиглалт, нэвтрүүлэлт харьцангуй “сул” түвшинд байгаа боловч ирээдүйд ХОУ-ыг улам хөгжүүлэн ашиглах ба үүнд шаардагдах нягтлан бодогчдын мэргэжлийн мэдлэг хангалттай түвшинд байна гэж дүгнэжээ.

Судалгааны хэсэг

Дижитал шилжилтийг эрчимтэй хэрэгжүүлж буй Голомт банк нь Монгол Улсын банкны системийн голлох 5 банкны нэг бөгөөд салбарын тогтолцоонд чухал байр суурь эзэлдэг. Голомт банкны нягтлан бодогч мэргэжилтэн болон холбогдох мэргэжилтнүүдээс асуулга болон ярилцлага хийж, баримт бичгийн боловсруулалт болон үйл ажиллагааны тайлангуудад үндэслэн энэхүү судалгааг хийлээ. Судалгаанд хамрагсдын 62% нь 20-30 насныхан байсан. Эдгээр нягтлан бодогчдын 28.0% нь 0-12 сар, 56.0% нь 1-10 жил, 19% нь 10-аас дээш жил тус банканд ажилласан байна.

Судалгаанд оролцогчдын ликертийн онооны дүнгээс, дижитал технологийн нөлөө ажилтан бүрдянз бүрээр илэрч байна (Зураг 1). Санхүүгийн тайлан бэлтгэх чиг үүргийг бүхий нягтлан бодогч нарын хувьд 31% нь ажлын чиг үүрэг нь хялбар болсон гэж үзэн 4-5 оноогоор үнэлсэн. Тооцоолол, анхан шатны баримт бүрдүүлэлтийг хийж гүйцэтгэдэг нягтлан бодогч нарын хувьд цаасан баримт хадгалалт өөрчлөгдөөгүй гэж үнэлэв. Энэ үр дүн ярилцлагаар ажиглагдсан ба банк дижитал шилжилт хийж, технологи нэвтрүүлсэн ч, бодитой

Зураг 1. Дижитал технологийн нөлөө




баримт мэдээллийг батлан шалгаж, мэдээллийн аюулгүй байдлын үүднээс бүрэн автоматжуулаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ERP систем ашиглах чадвар хамгийн их үнэлгээтэй (3.84) байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх (88%) нь ERP системүүдийг өдөр тутмын ажил үүргээ гүйцэтгэхэд ашиглаж, харьцангуй сайн түвшинд эзэмшсэн нь харагдаж байна (Зураг 2). Энэ нь байгууллага нэгдсэн бүртгэлийн системд бүрэн дасан зохицож, эзэмшиж буйг харуулна. Харин дундажаас бага түвшинд (2.72) хиймэл оюун ухаан хэрэглэгддэг нь нягтлан бодогчдын хэрэглээнд хараахан


нэвтрээгүй байх магадлалтайг харуулж байна. Энэ нь хиймэл оюун ухааны ойлголт, мэдлэг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хэрхэн хэрэглэгдэх боломжтой тухай дэлгэрүүлэн судлах шаардлагатай байгааг илтгэнэ.

Зөөлөн ур чадварын хэрэглээний дундаж оноо 3.16-3.52 хооронд гарсан (Зураг 3). Үүнээс багийн хамтын ажиллагаа (3.28), стратегийн шийдвэр дэмжих (3.32), дасан зохицох чадвар (3.22) зэрэг ур чадварууд дунджаас дээш түвшинд байна. Харин харилцааны ур чадвар (3.16) болон мэргэжлийн ёс зүй (3.52) харьцангуй чухалчлагдаж байгаа ч тасралтгүй хөгжих шаардлагыг харуулж байна.

Зураг 2. Техник ур чадварын хэрэглээ



Зураг 3. Зөөлөн ур чадварын хэрэглээ



Зөөлөн ур чадварын хөгжил нь зөвхөн байгууллагын дотоод үйл ажиллагаанд төдийгүй, технологийн шилжилтийг хүлээн зөвшөөрөх, дасан зохицох чадамжийг сайжруулахад чухал нөлөөтэй.

Дижитал технологийн хэрэгслийг нягтлан бодох бүртгэлдээ нэвтрүүлснээр уламжлалт үйлдэлд зарцуулах цаг хугацаа багассаны үр дүнд ажлын чиг үүргүүдэд өөрчлөлт орсон ба дээрх процесст дараах байдлаар оролцох болсон байна. Оролцогчдын 60 гаруй хувиас 3.29-3.54 оноо авсан чиг үүргүүд болох тайлан, мэдээллийн чанар сайжруулах, өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ хийж удирдлагатай зөвлөлдөх, хэлтэс хоорондын хамтын уялдааг нэмэгдүүлж, зөвлөх үүрэг гүйцэтгэх болсон байна. Энэ нь орчин үеийн нягтлан бодогчид зөвхөн тооцооны болон тайлангийн үүрэг гүйцэтгэхээс гадна байгууллагын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцож, мэдээлэлд суурилсан санал, зөвлөмж гаргах чиглэлд шилжиж байгааг илтгэнэ. Харин шинэ ур чадвар эзэмших, сургалт хөгжилд хамрагдах (2.66), бүтээлч байдлаа нэмэгдүүлэх, шинэ санаа боловсруулах (2.76) зэрэг чиглэлүүд хамгийн бага оноо

авсан нь анхаарал хандуулах асуудал болов. Голомт банкны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас дурдвал, Сүүлийн 2 жил дараалан шилдэг дижитал банкаар тодорсон ба 2024 онд нийт 1,600 хүн цаг хэмнэсэн үр дүн гарсан байна. Нягтлан бодогчийн ажлын үүрэг менежментийн шийдвэр гаргах, датад суурилсан анализ хийх, эрсдэлийн таамаглах зэрэг ур чадваруудыг шаардаж байна. Байгууллага дижитал шилжилтээ хэмжиж, үнэлэх, зохицуулах тодорхой арга барил, төлөвлөгөөтэй болсон. Иймд эрчимтэй шилжилтийн үед зөөлөн ба дижитал ур чадваруудыг хослуулсан шинэ үеийн нягтлангуудын эрэлт нэмэгдэж байна.

2011 оны 04 дүгээр сарын болон 2021 оны 04 дүгээр сарын нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтыг харьцуулан үзэхэд (Хүснэгт 1), үндсэн чиг үүргүүд нь суурь утгаараа төстэй боловч бусад чиг үүрэг нэмэгдсэн байгаа нь асуулгын үр дүн болох дотоод алба нэгжүүдтэй зөвлөлдөх замаар уялдаж ажиллах, шийдвэр гаргалтанд зөвлөх зэргээр мэдэгдэхүйц өөрчлөлт орсон. 2011 оны тодорхойлолтод гадаад хэл, компьютерын хэрэглээний программ дээр ажиллах

Зураг 4. Чиг үүргийн өөрчлөлт



Хүснэгт 1. Голомт банкны нягтлан бодогчийн ажлын байрны
тодорхойлолтын харьцуулалт

	2011/04/01	2021/04/09
Чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> - Цалин, урамшуулал, илүү цаг, тэтгэмж, амралтын мөнгө, татвар шимтгэлийн тооцоо, шилжүүлэг, тайлан. - Ажилтны зээл лимит, хоолны мөнгө, бусад авлага. ХЧА, жирэмсэн/ амаржсаны тэтгэмжийн тайлан, нэхэмжлэл. ЭМД, НД дэвтэр, хөдөлгөөн, баталгаажуулалт - ҮХ, БҮТЭЗ-ийн бүртгэл, элэгдэл, дахин үнэлгээ, тооллого, актлах, борлуулах. - Засвар, тохижилт, даатгал, татварын зардал. - Хангамжийн материал, бичиг хэрэг, маягт, хүнсний материалын тооцоо, тооллого, хяналт. - Дотоод хэрэглээний зардлын тооцоо, хяналт. Банкны касс, бэлэн мөнгө, бичиг баримтын балансын гадуурх бүртгэл. - Салбар нэгж, тооцооны төвүүдийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, зааварчилгаа өгөх. - Хангамжийн албаны менежер, нярав, үйлчилгээний ажилтнуудад хяналт тавих. 	<ul style="list-style-type: none"> - Цалин, урамшуулал, илүү цаг, тэтгэмж, амралтын мөнгө, татвар шимтгэлийн тооцоо, шилжүүлэг, тайлан. - Ажилтны зээл лимит, хоолны мөнгө, бусад авлага. ХЧА, жирэмсэн/ амаржсаны тэтгэмжийн тайлан, нэхэмжлэл. ЭМД, НД дэвтэр, хөдөлгөөн, баталгаажуулалт - ҮХ, БҮТЭЗ-ийн бүртгэл, элэгдэл, дахин үнэлгээ, тооллого, актлах, борлуулах. - Засвар, тохижилт, даатгал, татварын зардал. - Хангамжийн материал, бичиг хэрэг, маягт, хүнсний материалын тооцоо, тооллого, хяналт. - Дотоод хэрэглээний зардлын тооцоо, хяналт. Банкны касс, бэлэн мөнгө, бичиг баримтын балансын гадуурх бүртгэл. - Салбар нэгж, тооцооны төвүүдийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, зааварчилгаа өгөх. - Хангамжийн албаны менежер, нярав, үйлчилгээний ажилтнуудад хяналт тавих <p>Бусад:</p> <ul style="list-style-type: none"> - Бүртгэлийн программын шинэчлэл, сайжруулалтыг хариуцах - Өөрийн мэдлэг, туршлага болон ажил үүрэгтэй холбоотой мэдээллийг холбогдох нэгж, ажилтнуудтай хуваалцаж, зааж сургах - Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам, зааврыг хэрэгжүүлж, өдөр тутмын ажилдаа мөрдөж ажиллах.
Бусад холбоо	Аж ахуй, хангамж, бэлтгэн нийлүүлэлтийн чиглэлээр харилцдаг компаниуд, Татвар, Нийгмийн даатгалын хэлтэс	Дотоод салбар нэгж, СУГ, Аж ахуй, хангамж, бэлтгэн нийлүүлэлтийн чиглэлээр харилцдаг компаниуд
Тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> • Англи хэл – 51%-74% • Орос хэл – 26%-51% • Удирдан зохион байгуулах, баримт бичиг боловсруулах – 26%-51% • Санаачилгатай, судалгаа шинжилгээ хийх, багаар ажиллан, илтгэх – 51%-74% • Хариуцлага хүлээх чадвар – 75%+ • Microsoft Word болон Excel – 75%+ • Microsoft Power Point, интернэт хайлт хийх хэрэглээнд ашиглах – 51%-74% 	<ul style="list-style-type: none"> • Асуудал шийдвэрлэх, төлөвлөн зохион байгуулах, эерэг хандлагатай • Санаачилгатай, багаар ажиллах бусадтай харилцах • Суралцан хөгжих, дасан зохицох • Санхүүгийн мэдлэг • Эрсдэлийг урьдчилан тооцоолох • Дүрэм журам, стандартын дагуу • Программ, систем ашиглах • Баримт бичиг боловсруулах

чадвар, удирдан зохион байгуулах ур чадварууд давамгайлж байсан бол 2021 онд ерөнхий болон мэргэжлийн ур чадварыг асуудал шийдвэрлэх, дасан зохицох, багаар ажиллах, санхүүгийн мэдлэгтэй байх, дүрэм журам мөрдөх, мэдээлэл хамгаалах мэдлэгтэй байх зэрэг нь илүү өндөр түвшний хариуцлага хүлээх чадварыг шаардаж байна.

Дүгнэлт

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжил нь эдийн засгийн бүхий л салбарт зайлшгүй хэрэгцээтэй бөгөөд мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан, автоматжуулалтын хөгжил нь энэ мэргэжлийн үндсэн чиг үүрэг, хэрэгцээг шинэ түвшинд хүргэж илүү технологид суурилсан ур чадваруудыг эзэмшиж, стратегийн хувьд эрсдэлийн зөвлөх үүрэг гүйцэтгэх шаардлагатай болсон байна.

Дижитал шилжилт нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн орчныг тал бүрээс нь өөрчилж байгаа тул эдгээр өөрчлөлтөд дасан зохицох, тасралтгүй суралцах,

шинэ технологийг эзэмших нь зөвхөн хувь хүний бус, байгууллагын хувьд ч нягтлан бодогчдыг дижитал орчинд зөөлөн ба хатуу ур чадварыг хөгжүүлэх сургалтын тогтолцоог улам бүр боловсронгуй болгох шаардлагатай болж байна.

Дижитал шилжилт технологийг үр дүнтэй нэвтрүүлэх, үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой дараах санал зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- Нягтлан бодогч нар тайлан шинжлэх, эрсдэлийг урьдчилан таамаглах, зөвлөх, стратегийн шийдвэрт оролцох зэрэг үүрэгт илүү анхаарах. Алба, хэлтсийн хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, байгууллагын зорилгод чиглэсэн нэгдсэн шийдвэр гаргахад оролцох хэрэгтэй.
- Хүний нөөцийн мэргэжилтнүүд төлөвлөлтдөө дижиталчлалын нөлөөг харгалзан, ажлын чиг үүргийг шинэчлэн, түүнд тохирсон ажилтан бэлтгэх сургалтын төлөвлөгөөг боловсронгуй болгох, сайжруулах нь зүйтэй.

Ашигласан материал

- ACCA (2020). Future Ready: Accountancy Careers in the 2020s. Retrieved from: https://www.accaglobal.com/gb/en/professional-insights/pro-accountants-the-future/future_ready_2020s.html
- Chen, Y., Lu, C., & Li, Z. (2024). How Does Digital Transformation Affect Corporate Accounting Employees?. *China Journal of Accounting Research*, 17(4), 100391. <https://doi.org/10.1016/j.cjar.2024.100391>
- Januszewski, A., & Pietrysiak A. (2025). Impact of Digital Transformation on Accounting Profession in the Opinions of Accounting Firms' Employees. *Procedia Computer Science*, 270, 2386-2397. <https://doi.org/10.1016/j.procs.2025.09.360>
- Авирмэд, Д., Алтан-Эрдэнэ, Б., & Хүрэлбаатар, Б. (2018). Нягтлан бодох бүртгэлийн дадлагын сургалтын практикт мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглах нь. *Нягтлан бодох бүртгэлийн онол, практик*, 2(2), 129-136. <https://journal.num.edu.mn/accounting/article/view/3049>
- Авирмэд, Д., & Хүрэлбаатар, Б. (2021). Хиймэл оюун ухааны эрин дэх нягтлан бодох бүртгэлийн салбарын өнөөгийн байдал (Монгол Улсын жишээн дээр). *Нягтлан бодох бүртгэлийн онол, практик*, 5(1), 103-114. <https://journal.num.edu.mn/accounting/article/view/7354>
- Хишигбаяр, Л., & Лхагвасүрэн, Д. (2019). Цахим эрин үеийн нягтлан бодогчдод шаардагдах ур чадварын асуудалд. *Нягтлан бодох бүртгэлийн онол, практик*, 3(2), 117-122. <https://journal.num.edu.mn/accounting/article/view/7327>